

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Стандарт, хэмжил зүйн газар /СХЗГ/-ын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”, Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны 89 дүгээр тогтоолоор батлагдсан ” Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ явуулсан .

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2016-2020 оны үйл үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны Үндсэн чиглэл, УИХ, Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, салбарын хөтөлбөр, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлт, бусад мэдээ материалд тулгуурлан явуулсан.

2017 оныг “Чанар-өндөр бүтээмж, тогтвортой хөгжил”-ийн жил болгон зарлан Нийгмийн амьдралын бүхий л салбарт бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанар, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх, бодит үр дүн, үр өгөөж гархуйц зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эрч хүчээ улам нэмэгдүүлэх, шинэ санаа санаачлагыг эрэлхийлэн ажиллах, Менежментийн тогтолцооны ISO 9001 олон улсын стандартын нэвтрүүлсэн туршлага дээр үндэслэн Авлигын эсрэг олон улсын менежментийн ISO 37001 стандартыг нэвтрүүлэх, Бараа бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгахад Стандартчилал, тохирлын үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх, хэрэглэх, ашиглах механизмыг оновчтой болгох, Олон улсын итгэмжлэлийн форумд гишүүнээр элсэх, Номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага, Олон улсын итгэмжлэлийн форумын Олон талын хүрээнд харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт нэгдэх, Импортын хэмжих хэрэгслийн анхдагч баталгаажуулалт, загварын туршилтын үр дүнг хүлээн зөвшөөрөх, Үндэсний стандартын олон улсын түвшинг дээшлүүлэх, Менежментийн шинэ тогтолцооны олон улсын стандартын талаар аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилах, нэвтрүүлэх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын далайцыг нэмэгдүүлэх, Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход үйл ажиллагааг чиглүүлэн ажилласан байна.

Дээр дурьдсан зорилтын хүрээнд хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм, журмын тоог цөөлөх, хялбаршуулах, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн цаг хугацааг хэмнэх зорилгоор байгууллагаас үзүүлж байгаа ажил, үйлчилгээг Цахим хэлбэрт шилжүүлэх тал дээр ихээхэн санаачлага гарган ажилласан байна.

Нөгөө талаас Хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, аж ахуйн нэгж, байгууллагын идэвх санаачлага, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо”-ны ISO 9001 стандартыг нэвтрүүлэхэд Агентлагийн зүгээс сургалт сурталчилгаа, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд:

Монгол Улсад Чанарын дэд бүтцийг олон улсын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд, бүтээгдэхүүн, үйлчилгээ тогтоосон стандарт, шаардлагыг хангаж байгааг нотлоход, стандартчилал, итгэмжлэл, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, хяналт шалгалтын нийгэмд эзлэх үндсэн чиг үүргийг тодорхойлоход хамгийн түрүүнд хууль, эрх зүйн орчны шинэчлэл, өөрчлөлтийг хийх нь тэргүүн ээлжийн зорилт байсан. Энэхүү зорилтын хүрээнд “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийг УИХ-ын 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан.

“Хэмжил зүйн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Шадар сайдын Ажлын албанд хүргүүлсэн байна.

Эдийн засгийг эрчимжүүлэх хүрээнд Төв болон орон нутгийн СХЗХ-үүдийн урсгал зардлын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, өглөг авлагын мэдээ хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу сар бүр хяналт тавьж ажилласаны зэрэгцээ 2017 онд 4.0 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 140%-иар биелүүлсэн байна.

Төв орон нутгийн стандарт, хэмжил зүйн салбарын байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн жигд явуулахад төсвийн орлого, зарлагын тэнцвэрт байдлыг хангах, төсвийн байгууллагын үйл ажиллагааг бага зардлаар хэвийн явуулж төсөв хэмнэх зорилгоор урсгал зардлыг бууруулж байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар зохион байгуулан ажилласан байна.

Салбарын техникийн чадавхийг сайжруулах чиглэлээр Хөрөнгө оруулалт, гадаадын зээл, хандив, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрт тусгуулах чиглэлд гол анхаарлаа төвлөрүүлэн ажилласан.

Байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн Менежментийн тогтолцооны ISO 9001:2008 олон улсын стандартын шинэчилсэн хувилбар ISO 9001:2015-ын дагуу Францын баталгаажуулалтын байгууллага /AFNOR/-аар магадлан үнэлгээ хийлгэх, Менежментийн тогтолцооны олон улсын стандарт 9001:2015 -ын

шинэчилсэн хувилбарт шилжих зорилт дэвшүүлж, удирдлага, зохион байгуулалтын иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг Францын баталгаажуулалтын байгууллага /AFNOR/-аар 2017 оны 10 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд үнэлүүлж, ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлсэн тухай 2015/68385.2 тоот гэрчилгээг хүлээн авсан.

Менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлснээр олон улс, бүс нутгийн гишүүнчлэлтэй байгууллагуудын хэмжээнд манай агентлагийн нэр хүнд статус дээшилсэн, стандартчилал, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн чиглэлээр “Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр”-т нэгдэн орсон, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг Олон улсад хүлээн зөвшөөрсөн, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд их түлхэц болсон.

Байгууллагын хувьд үйл ажиллагаа илүү хяналттай, эмх цэгцтэй, хөнгөн шуурхай, баталгаа нотолгоотой болж, хэрэглэгч, үйлчүүлэгчийн сэтгэл ханамж дээшилсэн гээд давуу талууд бий болсон.

Номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын Олон талын хүрээнд харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр /PAC MLA/-т нэгдэх хүсэлтийн дагуу 2016 онд хийгдсэн ижил түвшний үнэлгээгээр илэрсэн 10 үл тохирол, 4 зөвлөмж, 7 анхаарах зүйлийг залруулах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан талаарх тайланг 2017 оны 01 дүгээр сард ижил түвшний үнэлгээний ажлын хэсэгт хүргүүлсэн. /PAC/-аас үл тохирлыг хангалттай залруулсан тухай албан ёсны мэдэгдлийг ирүүлж, 2017 оны 06 дугаар сард PAC MLA-д чанар (ISO 9001), байгаль орчин (ISO 14001), хүнсний аюулгүй байдал (ISO/TS 22003), бүтээгдэхүүн (ISO/IEC 17065)-ий баталгаажуулалтын төрлөөр нэгдэн орж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Олон улсын гэрээнд нэгдсэнээр үндэсний итгэмжлэлийн тогтолцоо олон улсын түвшинд нийцсэн болохоо нотлон харуулахаас гадна үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулан, гэрчлэх байгууллагуудын чадавхийг үндэсний ба олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэх ач холбогдолтой болсон. Үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээ хилийн чанадад гарахад давтан баталгаажуулалтаар орох шаардлагагүй, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжсэн ажиллагаа болсон байна.

Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт нэгдсэн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, таниулах ажлыг тогтмол явуулж байна.

Олон улсын итгэмжлэлийн форум /IAF/-д гишүүнээр элсэх өргөдлийг маягтын дагуу бөглөж, дагалдах чанарын гарын авлага, журмуудыг боловсруулж, төлбөрийн баримт, өргөдлийн хамт 2017 оны 7 сарын 03-ны өдөр IAF-ын нарийн бичгийн дарга нарын газарт илгээсэн.

Олон улсын байгууллагын журмын дагуу гишүүнээр элсэх өргөдөл, мэдээллийг IAF-ын бүх гишүүдэд 6 сарын хугацаанд танилцуулах, санал авах

ажиллагаа явагддаг журмын дагуу гишүүнчлэлийн асуудал хүлээгдэж байна.

Монгол улс Олон Улсын Цахилгаан Техникийн Комисс (IEC)-той 2001 оноос эхлэн хамтран ажиллаж байгаа бөгөөд хөгжиж буй орнуудад зориулсан “Түншлэгч орон” хөтөлбөрийн хүрээнд Цахилгаан техникийн стандартчиллын үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу оновчтой зохион байгуулахын тулд “Түншлэгч оронд Цахилгаан техникийн үндэсний хороо байгуулах удирдамж” баримт бичгийг MNS 6640:2016 үндэсний стандартаар баталж, Монгол Улсын Шадар сайдын тушаалаар цахилгаан, электрон техникийн салбарын стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын уялдааг хангах үүрэг бүхий Цахилгаан техникийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 2017 оны 1 дүгээр сард шинэчлэн батлуулсан байна.

Европын холбооны стандартчиллын байгууллага дахь Монгол Улсын гишүүнчлэлийн статусыг хамтран түншлэгч гишүүнээр дээшлүүлсэн нь Европын стандартыг нутагшуулах, стандарт боловсруулах үйл ажиллагаанд нээлттэй оролцох боломжийг бий болгосон.

Стандартчиллын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 27 дугаар тогтоолоор батлуулж, 2017 онд Үндэсний зөвлөлийн хуралдааныг график, төлөвлөгөөний дагуу явуулж, хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг холбогдох баримт бичгүүдэд стандарт, техникийн зохицуулалтын талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хүрээнд 156 стандартыг баталж, энэ онд баталсан нийт стандартын 38.1% нь Олон улс, Европын стандартын түвшинд хүрсэн байна.

Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисстой “Чөлөөт худалдааны хэлэлцээр”-ийг байгуулах ажлын хүрээнд тус Комиссын сайд В.Н.Корешковын Монгол Улсад 2017 оны 3 дугаар сарын 27-ноос 4 дүгээр сарын 1-ний хооронд хийсэн айлчлалын үеэр хоёр талын стандарт болон техникийн зохицуулалтын баримт бичгийг судлах, ижилтгэх, худалдаанд саад учруулж буй баримт бичгийн хязгаарлалтын тодорхой нөхцлүүдийг талууд зөвшилцөн нэг техникийн баримт бичиг, нэг тохирлын үнэлгээг худалдаанд хэрэглэхээр талууд харилцан зөвшилцсөн.

Энэхүү арга хэмжээний хүрээнд Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбооны хооронд худалдаан дахь тарифын бус хориг саадыг арилгах зорилгоор “Стандарт, хэмжил зүйн газар болон Евразийн эдийн засгийн комисс хоорондын техникийн зохицуулалт, итгэмжлэлийн салбарт хамтран ажиллахаар санамж бичиг” байгуулсан нь “Үндэсний чанарын хөтөлбөр”-т тусгагдсан экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, сүү, арьс шир, чацаргана, зөгийн балыг гадаад зах зээлд гаргахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Стандарт, хэмжил зүйн газар нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан их, дээд сургуулиудтай хамтран Чанарын дэд бүтцийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх боловсролын тогтолцоо бүрдүүлэх, Европын холбооны стандартчиллын боловсролын тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх хүрээнд Онол-практикийн бага

хурлыг Нийслэлийн боловсролын газар, Шинжлэх Ухааны Академи, Боловсролын хүрээлэн, МУИС, МУБИС, ШУТИС, ХУИС, Отгонтэнгэр их сургууль, МХЕГ, НМХГ зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж, Стандартчиллын инженер, чанарын менежерийн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэхэд баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлсон нь цаашид Монгол Улсад Стандартчилал, чанарын мэргэжилтэн бэлтгэх үндэс суурь бий болж байгаа юм.

Байгууллагын вэб сайтыг Монгол, Англи хэл дээр шинэчлэн боловсруулсан нь ДХБ-ын “Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээр”-ийн хүрээнд Гишүүн орнууд болон нийтэд мэдээлэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.

НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Салбарын бодлогын зорилтууд, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө “Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, СХЗГ-ын дарга Шадар сайдтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээнд туссан зорилт, хөтөлбөрийн хэрэгжилтийг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Стандарт , хэмжил зүйн газрын нэр заагдсан 13 арга хэмжээний биелэлтэнд үнэлгээ хийлээ.

Хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн байна.

Засгийн газрын үйл ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 13 арга хэмжээний биелэлт дараах байдалтай байна. Үүнд:

100 хувийн биелэлттэй арга хэмжээ-12

70 хувийн биелэлттэй арга хэмжээ-1

Нийт биелэлтийн дундаж хувь 97,7 байна.

1.2 Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 3 зорилтын хүрээнд 5 арга хэмжээ тусгагдсанаас бүгд 100 хувийн биелэлттэй байна.

1.3 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт:

Хууль тогтоомж, дээд газраас ирсэн шийдвэрүүдийг сурталчилах, биелэлтэд нь хяналт тавьж, хэрэгжилтийг хангах, тайланг нэгтгэн дүгнэх, дээд байгууллагад хүргүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газрын, 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу зохион байгуулж, Стандарт, хэмжил зүйн газарт хамаарал бүхий хууль тогтоомж, хуульд үүрэг болгосон заалт 2, Ерөнхийлөгчийн зарлиг 3, Үндэсний

аюулгүй байдлын зөвлөмж¹, Засгийн газрын тогтоол 5, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 6, Засгийн газрын албан даалгаврын 6 заалтыг тус тус хяналтанд авч хэрэгжилтийг ханган ажиллаж уг тогтоолын дагуу **“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”**-д заасан аргачлалын дагуу үнэлэхэд нийт 6 шийдвэрийн 23 заалтын хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

-100% биелэлттэй 20 арга хэмжээ,

-70% биелэлттэй 3 арга хэмжээ, Биелэлтийн дундаж үнэлгээ 96.0% байна.

1.4 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийн биелэлт:

Тайлангийн хугацаанд Стандарт, хэмжил зүйн газрын дарга буюу Төсвийн төвлөрүүлэн захирагчаас Монгол Улсын Шадар сайд буюу Төсвийн ерөнхийлөн захирагчтай 7 хөтөлбөрийн хүрээнд 27 арга хэмжээ нийлүүлэхээр төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжиж, гэрээний үзүүлэлтийн нийт оноо 99.6.% байна.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ:

2.1. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал:

Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлж байгаа талаар орон нутгийн хэлтэс, СХЗГ-ын зохион байгуулалтын үндсэн нэгжүүдэд Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад шалган, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолд заасан шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийлээ.

Стандарт, хэмжил зүйн газрын зохион байгуулалтын үндсэн нэгжүүд зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулж, төрийн үйлчилгээ үзүүлэх жагсаалтыг гаргаж, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүйн яамаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж хэвшсэн байна.

“MASM OnlineTV”-ээр дамжуулан СХЗГ-ын видео контент бий болгох ажлын хүрээнд www.youtube.com дээр MASM online TV суваг үүсгэж 27 видео контент оруулж байгууллагын үйл ажиллагааны талаар 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 279 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл гаргасан байна. Үүнээс:

Телевиз: 60 удаа

Радио: 9 удаа

Байгууллагын вэб хуудас: 144 удаа

Бусад олон нийтийн вэб хуудас: 32 удаа

Сонин: 7 удаа

“Стандарт, хэмжил зүй” сэтгүүлийн 4 дугаарыг 2200 ш хэвлүүлж, олон нийтэд түгээсэн.

Заавал мөрдөх эрх зүйн хэм хэмжээ бүхий нийт стандартыг хэрэглэгчийн хэрэгцээнд www.estandard.mn веб-д нээлттэй байршуулсан байна.

“Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсгийн үндэслэн Монгол Улсын Шадар сайдын тушаалаар “Хэмжил зүйн зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн баталсанаар Хэмжил зүйн зөвлөлийн үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлага, дэлхийн улс орны жишигт нийцүүлэн “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах” шинжлэх ухаан, техникийн, зохион байгуулалтын болон эрх зүйн үндэсийг боловсронгуй болгох, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хангах асуудлыг хэмжил зүйн салбарт мэргэшсэн, нэр хүнд бүхий мэргэжилтнүүд, тухайн салбарын, шинжлэх ухааны байгууллагын эрдэмтэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийн хүрээнд хэлэлцүүлэн үр дүнтэйгээр шийдвэрлүүлэх, ил тод ажиллах бодит нөхцөл бүрдсэн.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, давхардал чирэгдэл үүсгэхгүй, бизнес эрхлэгчдэд хөнгөлөлт үзүүлэх зорилгоор “Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах тусгай зөвшөөрлийг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагад тавих ерөнхий шаардлага”-ын стандартыг батлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэмжил зүйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод, түргэн шуурхай болгох зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад үйл ажиллагаандаа чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, бодлогоор дэмжихэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авч хэвшсэн байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар гадны байгууллагаас нийт 2471 албан бичгийг хүлээн авч тогтоосон хугацаанд шийдвэрлэсэн байна. Байгууллагаас гадагш чиглэсэн 1134 албан бичгийг илгээсэн байна. Нийт 167 өргөдөл хүлээн авч “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуульд заасан хугацаанд 159 өргөдөлд хариу өгч шийдвэрлэсэн байна.

2.2. Хүний нөөцийн ил тод байдал:

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 09 дүгээр тушаалын дагуу Байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй уялдсан хүний нөөцийг бүрдүүлэх, төрийн жинхэнэ албан тушаалд томилох, шилж сонгох, шаардлагатай мэдлэг

чадвар, туршлага бүхий хэрэгцээтэй орон тоонд зөв хуваарилан хүний нөөцийг зохистой хэмжээнд ханган ажилласан.

Стандарт, хэмжил зүйн газар нь удирдлагын менежментийг боловсронгуй болгох, ажлын байрны ачааллыг нягтруулах, шаардлагагүй шат дамжлагыг багасгах, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх чиглэлээр хүний нөөцийн стратеги хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллан, ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, үр дүнгийн гэрээ шинэчлэн баталгаажуулах ажлыг зохион байгуулсан.

Ажлын байрны орчин, хэвийн үйл ажиллагааг хангахад аж ахуй, үйлчилгээний туслах чиг үүргийн ажиллагсдыг гэрээгээр ажиллуулж байна.

Ажлын мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах нөхцлийг бүрдүүлэх үүднээс ажилтан сонгон шалгаруулж авахдаа шудрага, нээлттэй, ил тод, тэгш хандах, өрсөлдүүлэн шалгаруулах зарчмыг баримталж байна.

Боловсон хүчнийг чадваржуулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:

Төрийн албан хаагчийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх чиглэлээр Удирдлагын академиас зохион байгуулах сургалтад ажлын байрны чиг үүргийн дагуу хамруулсан.

Европын холбооны “Монгол Улсын Стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх” төслийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын албан нийт албан хаагчдад Мэргэжлийн англи хэлний сургалтыг зохион байгуулж байна.

Төслийн хүрээнд давхардсан тоогоор салбарын хэмжээнд 1000 гаруй ажилтан, албан хаагчид мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.

Эрхэлж байгаа ажлын чиглэлээр албан хаагчдын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх зорилгоор урт, дунд, богино хугацааны гадаад, дотоодын сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан.

Ажлын байранд нь сургаж дадлагажуулах, ахмад ажилтныг дагалдуулан ажиллуулах, зөвлөгөө өгөх ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу тус тус зохион байгуулж байна.

2.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал:

Байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь гарган Сангийн яам, Шадар сайдын ажлын албанд хүргүүлж, аудитийн үнэлгээ хийлгэж батлагаажуулсан. Үндэсний аудитын газар /ҮАГ/-аас “зөрчилгүй” дүгнэлттэй тайлан авсан. Мөн 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын тайлан ҮАГ-ын гүйцэтгэлийн аудитын үнэлгээ “зөрчилгүй” санал дүгнэлттэй гарсан болно.

Санхүүгийн бүртгэлийг УСНББОУС-ын дагуу хөтлөн явуулж цаг хугацаанд нь үнэн зөв тайлагнах зорилгоор газар бүрийн орлого нийлэх, гэрээний биелэлтийг хангуулах, бүртгэл тооцоо, касс, харилцахын орлого, зарлагын гүйлгээг батлагдсан маягт зааврын дагуу гүйцэтгэж, анхан шатны баримтыг бүрдэлтэнд хяналт тавьж ажиллалаа. Шилэн дансны тухай хууль, журамд заасан мэдээллийг байгууллагын өөрийн цахим хуудсаар хүргэн, шилэн дансны бие даасан цэсийг бий болгон, мэдээлэлтэй холбоотой тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулан, ил тод байдлыг ханган ажилласан.

Байгууллагын эрхлэн явуулдаг үйл ажиллагааны чиглэлээр зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийг үйлчүүлэгчээс авч байгаа бөгөөд төлбөр хураамжийн хэмжээг мэдээллийн самбар, цахим хэлбэрээр мэдээлж байна.

2.4. Бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал:

Стандарт, хэмжил зүйн газарт бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зориулж Улсын Их Хурлаас баталсан төсвийн хүрээнд хэрэгжилтийг ханган ажилласан.

Худалдан авах үйл ажиллагаа, тендертэй холбоотой баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг нийтэд мэдээлж, цахим хуудас /www.masm.gov.mn, www.e-procurement.mn/-т байршуулж байгаа бөгөөд 2017 онд Сорьцын хяналтын байрны агааржуулалтын хоолойг солих ажиллагааг гэрээний үндсэн явуулсан.

ЦААШИД ДЭВШҮҮЛЖ БАЙГАА ЗОРИЛТУУД :

1. "Хэмжил зүйн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барих
2. Шинэчлэн батлагдсан хуульд нийцүүлэн үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм, журмыг Европын холбооны нийтлэг зарчмын дагуу боловсруулах
3. Үндэсний стандартын шинжлэх ухаан техникийн улсын үзлэг явуулах ;
4. Салбараас боловсруулсан төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх;
5. Менежментийн тогтолцооны олон улсын ISO 9001 стандартыг нэвтрүүлсэн бааз суурь дээр үндэслэн Авлигын эсрэг олон улсын ISO 37001 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах;

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР